

## Шилжлэг салхи /Wind shear/

Агаарын урсгалын огцом өөрчлөлтийг шилжлэг салхи гэнэ. Шилжлэг салхийг ажиглагдах байдлаар нь 3 хуваана. Үүнд:

- а. Чиглэлийн өөрчлөлт
- б. Хурдны өөрчлөлт
- в. Чиглэл хурдны өөрчлөлт

Салхины хурд ба чиглэл ойрхон зайд, огцом өөрчлөгдсөнөөр онгоцны далавчийг тойрон урсах агаарын жигд урсгалыг бусниулж, аэродинамик хүч өөрчлөгдсөнөөр агаарын хөлгийн тэнцвэрийг алдагдуулахад хүргэнэ. Ялангуяа агаарын хөлгийн буултанд хамгийн аюултай байдаг. Учир нь салхины хүч огцом багасах, гэнэт ихсэх нь товлосон цэгт газардах үйл ажиллагааг өөрчилж, осол сүйрэл гаргахад хүргэдэг. Хөөрөх үед өндөр авалтын аюулгүй доод хязгаар алдагдаж барилга байгууламж, уул толгод, ургаа мод шүргэх, мөргөх аюултай.

Салхины шилжлэгийн босоо тархалт ХБЗ-аас дунджаар 100 м хүртэлх өндөрт хамгийн эрчимтэй, 100-500 метрт арай бага эрчимтэй тохиолддог болохыг судалгаагаар тогтоосон байна.

### Шилжлэг салхи үүсэх синоптик нөхцөл:

1. Дулаан, хүйтэн фронт дайрч өнгөрөх,
2. Газар орчим хүчтэй салхи ажиглагдах ба орон нутгийн уул зүйн нөлөөтэй хавсрах,
3. 12 м/с-ээс их хурдтай салхи уул давж салхилах үед уулын нөмөрт "уулын долгион" салхи үүсэх,
4. Дулааны улиралд борооны бөөн үүл үүсч аадар бороо орох, аянга цахилгаан ажиглагдах,
5. Өвлийн улиралд хонхор хотгор газар нам өндөрт инверси үүсэх
6. Эх газар, далай тэнгисийн зааг бүсэд "эргийн салхи" ажиглагдах

### Шилжлэг салхийг илрүүлэх тоног төхөөрөмж

1. Wind profiler
2. Wind Lidar
3. Doppler Radar
4. Low level wind shear alert system /Нам өндрийн шилжлэг салхи илрүүлэгч/